



“МЭРЭ” ХХК-ийн НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ  
“ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2025  
ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

---

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2619687

2025 он

**ГАРЧИГ**

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
II. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	10
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	11
IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
V. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	31
VI. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	33
VII. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
VIII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	41
IX. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	49
X. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	52
XI. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	55

**ТӨЛӨВЛӨГӨӨ ДЭХ ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Төсөл хэрэгжиж буй байршил /*Google earth/ .....	5
Зураг 2. Үйлдвэр, агуулахын бүсийн сансрын зураг /*Google Earth-2024/ .....	5
Зураг 3. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэл .....	6
Зураг 4. Өдөөгчийн үйлдвэр .....	6
Зураг 5. Нонель хэрэгсэл угсрах үйлдвэр .....	7
Зураг 6. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах .....	7
Зураг 7. Захиргаа, аж ахуйн барилгын харагдах байдал .....	8
Зураг 8. Тусгайлан тоногдсон туршилтын талбай .....	9
Зураг 9. Үйлдвэрийн хяналтын лаборатори .....	9
Зураг 10. Т14 үйлдвэрийн агааржуулалтын системийг засварлах явц .....	13
Зураг 11. Химийн бодисын агуулах шалгах хуудас .....	14
Зураг 12. Тээврийн хэрэгслийн үзлэг, засварын бүртгэл .....	15
Зураг 13. Ажлын байрны үзлэгийн бүртгэл .....	18
Зураг 14. Түүхий эд , шатах материалын хадгалалт .....	19
Зураг 15. Барилга байгууламжийн үзлэг шалгалтын тайлан .....	20
Зураг 16. Үзлэгээр илэрсэн үл тохирол .....	20
Зураг 17. Үзлэгийн хуудас .....	21
Зураг 18 Хувцас, хамгаалах хэрэгсэл олгох журам .....	24
Зураг 19 Дөрөвдүгээр эмнэлэгт үзлэгт хамрагдаж буй явц .....	25
Зураг 20 Ажлын байр тус бүрд зайлшгүй ашиглах хувцас хамгаалах хэрэгслийн бүрдэл, олголт .....	25
Зураг 21 Шинэ ажилтны сургалтын материалын жагсаалт .....	26
Зураг 22 Нийт ажилтны сургалтын хөтөлбөр .....	27
Зураг 23 Галын аюулгүй байдлын дүгнэлт .....	28
Зураг 24 Галын аюулгүй байдлын дүгнэлт .....	29
Зураг 25 Хөдөлмөрлөх нөхцөлийн үнэлгээний тайлангийн нүүр .....	30
Зураг 26 Хөдөлмөрлөх нөхцлийн үнэлгээний дүгнэлт .....	30
Зураг 27 Мод тарилт .....	31
Зураг 28. Мод усалгаа .....	32
Зураг 29. Ололт амжилт сургадтын төвөөс зохион байгуулсан нийт ажилтны сургалт .....	35
Зураг 30. Нийт ажилтны сургалт .....	35
Зураг 31. Анхны тусламжийн сургалт .....	35
Зураг 32. Онцгой байдлын үеийн дадлага .....	36
Зураг 33. Сургалтын баталгаажуулах үнэмлэх .....	37
Зураг 34. Сэрээт ачигчийн аюулгүй ажиллагаа .....	37
Зураг 35. Онцгой байдлын үеийн дадлага .....	37
Зураг 36. Асгаралтын хэрэгсэл .....	38
Зураг 37. Түүхий эд байршуулах план зураг .....	38
Зураг 38. Өдөр тутмын эрсдэлийн үнэлгээний бүртгэл .....	39
Зураг 39. АМХ бүртгэл .....	39
Зураг 40. Зааварчилгаа өгсөн бүртгэл .....	40
Зураг 41. Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдын зохицуулалтын хэмжээ .....	42
Зураг 42. Аюултай хог хаягдлын бүртгэл .....	42
Зураг 43. Химийн бодисын хаягдал шилжүүлэлт .....	43
Зураг 44. Тусгай зөвшөөрөл .....	44
Зураг 45. АХХ шилжүүлэх гэрээ .....	44

Зураг 46. Салбараас эрх бүхий байгууллага руу АХХ тээвэрлэсэн бүртгэл .....	45
Зураг 47 АХХ шилжүүлэх гэрээ .....	46
Зураг 48. Сургалтын бүртгэл.....	47
Зураг 49. Цахим хаягдал нийлүүлэх гэрээ .....	48
Зураг 50. Дугуй нийлүүлэх гэрээ .....	48
Зураг 51. Нийтийн цэвэрлэгээ .....	53
Зураг 52. Стандартын баталгаажуулсан тайлан .....	54

### **ТӨЛӨВЛӨГӨӨ ДЭХ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Төслийн хэрэгжиж буй талбайн байр зүйн солбицол .....	4
Хүснэгт 2. Лабораторид гүйцэтгэж буй сорилтууд .....	9
Хүснэгт 3. Тухайн жилийн БОМТ нийт зардлын нэгтгэл .....	11

**I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА****Төслийн хэрэгжүүлэгч:**

“МЕРА”ХХК

**Төслийн нэр:**

“Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах”

**Улсын бүртгэлийн дугаар:** 9011108011**Регистрийн дугаар:** 2619687**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Монгол улс-210644, Улаанбаатар хот | Сити Тауэр /17 давхарт/, Чингис хааны нэрэмжит талбай 1, 8-р хороо Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол улс, 14200


**Утас:** 75 55 66 77 **Факс:** 11 319276 |**Төслийн байршил.**

Налайх дүүргийн Засаг Даргын 2022 оны 08-р сарын 17-ны өдрийн А/228 тоот шийдвэрийг үндэслэн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 1261610685 нэгж талбарын дугаар бүхий 158054 м<sup>2</sup> газрыг (15.8 га) үйлдвэрлэлийн зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр гэрчилгээ олгогдсон. ҮАЦ нь Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт Улаанбаатар хотоос зүүн урагш 45км, Налайх дүүргийн төвөөс баруун урагш 2.4 км зайтай байрладаг.

**Хүснэгт 1. Төслийн хэрэгжиж буй талбайн байр зүйн солбицол**

#	X	Y
1	47° 44.727'N	107° 15.022'E
2	47° 44.726'N	107° 14.813'E
3	47° 44.754'N	107° 14.769'E
4	47° 44.870'N	107° 14.767'E
5	47° 44.871'N	107° 14.890'E
6	47° 44.925'N	107° 14.890'E
7	47° 44.929'N	107° 15.117'E
8	47° 44.668'N	107° 15.118'E
9	47° 44.669'N	107° 15.022'E

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн шаардлагын дагуу үйлдвэр нь байнгын их хөдөлгөөнтэй зам, улсын чанартай объект, хүн ам бүхий сууринаас нэг километрийн зайтай байх, бэлэн бүтээгдэхүүн болон түүхий эдээ төмөр зам болон авто замаар тээвэрлэх боломжтой, өндөр хүчдэлийн цахилгаан шугамд холбогдох боломжоор хангагдсан байх шаардлагыг үндэслэн үйлдвэрийн байрлалыг Налайх-Чойр чиглэлийн автозамаас 950 метр, Улаанбаатар-Замын үүд чиглэлийн төмөр замаас 15 км зайд, цэргийн локаторын ангиас 930 метр алслагдсан зайд сонгон байгуулсан.



*Зураг 1. Төсөл хэрэгжиж буй байршил /\*Google earth/*



*Зураг 2. Үйлдвэр, агуулахын бүсийн сансрын зураг /\*Google Earth-2024/*

## Төслийн хүчин чадал

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын төслийн хүрээнд энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх T11, өдөөгч тэсрэх бодис үйлдвэрлэх T14 үйлдвэр, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх T15 үйлдвэрүүд үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна. Мөн төслийн талбайд бүтээгдэхүүний чанарт хяналт тавих лаборатори, туршилтын полигон, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахуудыг цогцоор барьж байгуулсан.

### T11 үйлдвэр

T11 үйлдвэр нь жилдээ 6000тн "Аянга", Хүчитгэсэн буюу "Аянга-Х" тэсрэх бодисууд үйлдвэрлэн харилцагч байгууллагуудад нийлүүлж байна. Аммикийн нитрат (аммикийн шүү), дизелийн түлш, хөнгөн цагааны нунтаг зэрэг химийн бодисыг үйлдвэрийн технологийн үйлдвэрлэл буюу бүтээгдэхүүний найрлагын түүхий эд байдлаар ашигладаг.



Зураг 3. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэл

### Өдөөгчийн тэсрэх бодис үйлдвэрлэх T14 үйлдвэр

Монгол Улсын уул уурхай, зам, барилгын салбарын тэсэлгээний ажилд 100% импортлон ашиглаж буй өдөөгчийг үйлдвэрлэнэ. Энэхүү өдөөгч нь сул мэдрэх чадвартай тэсрэх бодис болон тэсэлгээний үндсэн цэнэгийг өдөөж тэслэх зориулалттай. Уул уурхай, зам, барилгын тэсэлгээнд хэрэглэх зорилгоор төрөл бүрийн хэмжээгээр үйлдвэрлэдэг бөгөөд жилд 500 тонн өдөөгч үйлдвэрлэх хүчин чадалтай.



Зураг 4. Өдөөгчийн үйлдвэр

### Тэсэлгээний хэрэгсэл угсрах T15 үйлдвэр

Уул уурхайн салбарт чанартай, хямд, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэн үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, компанийн үйлдвэрлэлийн салбарыг нэмэгдүүлэх зорилгоор АНУ-ийн Аустин детонатор компанийн жилд 1,300,000 ширхэг цахилгаан бус хэрэгсэл угсрах хүчин чадал бүхий үйлдвэр юм.



Зураг 5. Нонель хэрэгсэл угсрах үйлдвэр

### Агуулахууд

Үйлдвэрийн агуулахууд нь түүхий эд, туслах материалын, импортын эмульсийн тэсрэх бодисын, тэсэлгээний хэрэгслийн, бүтээгдэхүүний (ANFO) гэж ангилагдах бөгөөд агуулахын хамгийн их багтаамж нь (аммиакийн шүү орохгүйгээр)-120 тн, үүнээс ЭТБ-100 тн, Эмульсийн тэсрэх бодис-1100 тн, аммиакийн шүү-1500 тн, бусад тэсэлгээний хэрэгсэл хадгалах хүчин чадалтай.

Налайхын тэсрэх бодис, түүхий эд материалын агуулахуудыг ТАААНД-ийн шаардлагын дагуу тоногдсон бөгөөд эдэлбэрийн зүүн хэсгийг шороон далангаар тусгаарлан, аянга зайлуулагчаар аянгаас хамгаалсан дөрөв дөрвөөр нь зэрэгцүүлэн барьсан. агуулахуудад хадгалдаг.



Зураг 6. Тэсрэх материал, түүхий эдийн агуулах

### Захиргаа аж ахуйн барилга

Үйлдвэрийн захиргаа, аж ахуйн хэсэг үйлдвэрийн хойд хэсэгт байрладаг давхар барилгын баруун жигүүрт байрладаг ба өнгөрсөн хугацаанд барилга дотор явуулж буй үйл

ажиллагаанд өөрчлөлт оруулаагүй. 2020 онд орон тоо нэмэгдэж буйтай холбоотой оффисын барилгад өргөтгөл хийж, ажиллах нөхцөл, орчныг сайжруулахаар төлөвлөн, ажлын зураг хийлгэж бэлэн болсон.

Энэхүү барилгад тус албан контор, ажилчдын цайны газар, ажилчдын 1 ээлжийн душ, хувцас угаалгын хэсэг, халаалтын блок, хувцас солих өрөө гэх мэт өрөө тасалгаануудтай ба лабораторийн хэсэг нь 2-р бүс рүү нэвтрэх харуулын постын хажууд байршина.

Мөн үйлдвэрийн байр, бэлэн бүтээгдэхүүний болон түүхий эдийн агуулах, оффисын барилга зэрэг шаардлагатай газруудад 72 ширхэг хяналтын камер байрлуулан интернэтийн сүлжээтэй байрлалаас 24 цагийн турш хянаж байна.



*Зураг 7. Захиргаа, аж ахуйн барилгын харагдах байдал*

**Үйлдвэрийн лаборатори**

Үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүний чанарын хяналтыг үйлдвэрийн лабораториор хянаж ажилладаг ба үйлдвэрийн гадна талбайд зөвшөөрөгдсөн зайд тусгайлан тоноглож байгуулсан туршилтын талбайд бүтээгдэхүүний туршилтын ажлыг мэргэжлийн эрх бүхий үнэмлэхтэй тэсэлгээчид гүйцэтгэдэг.



**Зураг 9. Үйлдвэрийн хяналтын лаборатори**



**Зураг 8. Тусгайлан тоногдсон туршилтын талбай**

**Хүснэгт 2. Лабораторид гүйцэтгэж буй сорилтууд**

Сорилт хийх материалын нэр	Гүйцэтгэж байгаа сорилтын төрөл
Аммонийн нитратын механик сорилт	Шингээх чадвар
Дизель түлшний үзүүлэлтүүд	Хүлээн авах үеийн хяналт
“Аянга” бүтээгдэхүүний түүхий эд	Орц найрлага
Тэсрэх бодисын өдөөгч	Өдөөлтийн эрчим, хүч

## II. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### Физик газарзүй:

Налайх дүүрэг нь газарзүйн байршлын хувьд Хэнтийн уулархаг мужид хамаарагдана. Геоморфологийн хувьд голын татмын дэвсгэр нутаг болох бөгөөд голын татмаар нэвчилт шүүрэлт ихтэй сийрэгдүү, элс сайр, сайрган, хайргархаг аллювийн хурдас зонхилно.

### Цаг уур, уур амьсгал:

Уур амьсгалын үндсэн нөхцөл нь эх газрын эрс тэс цаг агаарын шинжтэй, хот орчмын бичил, бэсрэг уур амьсгалын онцлогтой. Налайх орчмын агаарын температур өвөл 18.80 - 22.70, зун 12.80 - 15.40, Жилд унах тунадасны хэмжээ 260-290 мм, жилийн дундаж агаарын даралт 852.3 гПа, дундаж салхины хурд жилд 4.2 м/с байна.

### Гадаргын болон газар доорх ус:

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор орчимд гадаргын ус байхгүй. Налайх орчмын гидрогеологийн зурагт тэмдэглэснээр Налайхын нүүрсний уурхай орчимд Туул голын хөндийд газрын доорх устай аллювийн хурдас, Налайхын хотгорт их талбайд тархалттай, бага нөөцтэй газрын доорх устай доод цэрдийн хурдас, үндсэндээ усгүй неогений хурдас тус тус тархсан байна.

### Хөрс, ургамал, амьтан:

Хөрс газарзүйн мужлалаар уулын хар хүрэн, хар шороон, уулын тайгын ширэгт, уулын ойн бараан хөрстэй Хэнтийн өмнөт тойрогт багтдаг. Үйлдвэр байрлаж буй газрын хэмжээнд хээрийн хөнгөн шавранцар хар хүрэн хөрс зонхилон тархана.

Ургамалжилтын ангиллаар Бага Хэнтийн уулархаг мужийн уулын хээр, нам толгодын хөндий, тал хээрийн бүсэд багтана. Налайхаас зүүн урагш Баянгийн овоо, Баян-Уул хүртэл уулын хээрийн хөнгөн шавранцар хөнгөн хөрстэй, жижиг үетэн-алаг өвст, чулуурхаг нам толгодоор үетэн-алаг өвст-үетэн-агьт бүлгэмдэл тааралдана. Налайх суурингийн орчим Хонхор нуур хүртэл нам толгодын бэл хөндийгөөр үетэн-агьт, үетэн-алаг өвс-шарилжит, үетэн шарилжит бүлгэмдэлтэй талхлагдсан бэлчээр зонхилно.

Амьтны аймгийн мужлалаар Хэнтийн тойрогт багтана. Налайх дүүрэг орчимд цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад багтана.

### Нийгэм-эдийн засаг:

Налайх дүүрэг нь Засаг захиргааны 7 хороотой. 5 болон 6 дугаар хороод нь жуулчдыг татдаг байгалийн үзэсгэлэнт газар болох Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт байрладаг.

Монгол Улсын авто замын босоо болон хэвтээ тэнхлэгийн огтлолцолд оршдог, авто зам, төмөр зам, агаарын тээвэр хөгжсөн, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй, нийслэлийг цэвэр усаар хангаж байгаа дээд эх үүсвэртэй шууд холбогдсон, Монгол орны аялал жуулчлалын гол бүс нутаг хамаардаг, хүн амын дийлэнх олонхыг залуучууд болон хөдөлмөрийн насныхан эзэлдэг, түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт ихтэй зэрэг давуу тал олон.

### III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Түүхий эд болон бэлэн болсон бүтээгдэхүүнийг ачиж буулгах, тээвэрлэх явцад хөрс элэгдэх, эвдрэх, агаарт тоос дэгдэх, хог хаягдал, түүхий эдийг ил задгай хаяснаас хөрсний бохирдол үүсэх, автомашины хөдөлгөөнөөс үүдэн зам орчмын ургамлан бүрхэвчид нарийн ширхэгт тоос тогтож улмаар ургалтад нь сөргөөр нөлөөлөх зэргээр үйлдвэр агуулахын цогцолбор төслөөс байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой байдаг.

#### БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ ЗОРИЛТ

“МЕРА” ХХК нь энгийн тэсрэх бодис, задгай болон савласан эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл хамгийн бага түвшинд байлгахыг 2025 онд зорилт болгон ажиллаж байна.

- Монгол улсын Үндсэн хууль болон бусад байгаль орчинтой холбоотой хууль, дүрэм журам, стандартуудын хүрээнд үйл ажиллагаа явуулах.
- Байгалийн нөөц баялгийг ариг гамтай ашиглаж, үйл ажиллагаанаас бий болсон хоёрдогч түүхий эд, материалыг зүй зохистой ашиглах ба дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- Сум орон нутгийн байгууллагатай байгаль орчин нийгмийн хүрээнд хамтран ажиллаж, төслийн үйл ажиллагааг нээлттэй байлгах.
- “Байгаль орчны менежментийн тогтолцоо, шаардлага, хэрэглэх арга зүйн заавар MNS ISO 14001:2016” стандартын хэрэгжилтийн нийцтэй байдлын талаарх магадлах гадаад аудитыг хийлгэж, байгальд сөрөг нөлөөлөл багатай техник, технологиор үйл ажиллагаагаа явуулж, учирч болзошгүй эрсдэлүүдийг байнгын хяналтдаа байлгах.
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний сайжруулалтыг хийж, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг тодорхойлох.
- Үйл ажиллагааны процессуудын эрсдэлийн тодорхойлж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.

#### Хүснэгт 3. Тухайн жилийн БОМТ нийт зардлын нэгтгэл

Дд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тухайн жилийн БОМТ-д төлөвлөсөн зардал /төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,460,000.00
2	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	2,000,000.00
3	Ногоон байгууламжийн төлөвлөгөө	6,000,000.00
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,900,000.00
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,000,000.00
6	Орчны хяналт шинжилгээний мониторинг	905,000.00
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>16,665,000.00</b>

#### IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

##### IV.1 Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Дотоод болон гадаад орчны агаарын бохирдол	T14 үйлдвэрийн ажиллах орчны агаарын урсгалыг сайжруулах	Төслийн барилга байгууламж	2025 онд	Үйлдвэрийн агааржуулалтын орчныг сайжруулах зорилгоор T14 үйлдвэрийн агааржуулалтын системийг шинэчлэн засварласан. Дэлгэрэнгүй мэдээллийг <b>IV.1.1</b> -ээс танилцана уу.
2	Агаарын бохирдол	Ажлын байр, агуулах, авто засвар автогаш зэрэг барилгуудын агааржуулалтын системийн хэвийн ажиллагааг хангах	Төслийн барилга байгууламж	2025 онд	ХАБЭАБО-ны хэлтсийн АБҮ-н хуваарийн дагуу үзлэг шалгалтыг тогтмол хийж байна. Үйл ажиллагааны хүрээнд барилга объектын агаар сэлгэлтийг сайжруулах, агааржуулалтын системийн засвар үйлчилгээг хийх төлөвлөгөөг гарган ажилласан. Дэлгэрэнгүй мэдээллийг <b>IV.1.1</b> -ээс танилцана уу.
3		Төсөл орчмоос гарч байгаа дуу чимээний хэмжилтийн үр дүнд үндэслэн давсан тохиолдолд эх үүсвэрийг тодорхойлж, нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах	Төслийн хэмжээнд	2025 онд	<b>Захиргааны хяналт:</b> Дуу чимээний өртөх эрсдэлтэй ажилтнуудыг жил бүрийн <b>ЭМҮ-н хүрээнд чих</b> хамар хоолойн үзлэгт хамруулсан. <b>НБХХ- хангах:</b> Сонсгол хамгаалах хэрэгслийг дотоод журмын дагуу олгох, ашиглуулах арга хэмжээг зохион байгуулсан.
4		Тэсэлгээний бодисыг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэрээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй нөхцөлд, зориулалтын сав баглаа боодол, контейнерт хадгалах.	Төслийн хэмжээнд	Тогтмол	Төслийн хэмжээнд нийт 6 агуулах ашиглалтад байгаа бөгөөд тус агуулахууд нь <b>үндсэн түүхий эдийн, химийн бодисын, тэсэлгээний хэрэгслийн, болон бүтээгдэхүүн хадгалах зориулалттайгаар</b> ашиглагдаж байна. Тус агуулахууд нь MNS 6458:2014 Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах, Ерөнхий шаардлага стандартыг бүрэн хангаж буй <b>Байгаль орчны улсын хяналтын байцаагчийн дүгнэлт</b> хуудсаар баталгаажсан.
5	Авто машин, техникийн хөдөлгүүрээс үүсэх хийн бохирдол	Бүх тээврийн хэрэгсэл, хүнд машин механизм, техникийг тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээ хийх	Төслийн хэмжээнд	Тогтмол	2025 онд салбарт нийт 2 удаагийн урсгал засвар, 10 удаагийн төлөвлөгөөт үзлэг засвар, 3 удаагийн төлөвлөгөөт бус засварыг хийж гүйцэтгэсэн байна.

#### IV.1.1 Агааржуулалтын системийн хяналт, засвар үйлчилгээ, сайжруулалт

Төслийн хүрээнд тэсэлгээний хэрэгсэл, өдөөгчийн 3 үйлдвэр, үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах агуулах, тэсрэх материал, хэрэгсэл хадгалах агуулах, лабораторийн туршилтын байр тус тус ашиглагдаж байна.

Дээрх объектуудаас зарим агуулахууд нь байгалийн агаар сэлгэлтийн системтэй бол үйлдвэр хосолмол агааржуулалтын системтэй буюу агаар сорох амсар, хоолойноос бүрдэнэ.

2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд: Т14 үйлдвэрийн агааржуулалтыг засварлан сайжруулалт хийсэн.



Зураг 10. Т14 үйлдвэрийн агааржуулалтын системийг засварлах явц

#### IV.1.2 Дуу чимээний өртөлтөөс хамгаалах арга хэмжээ



НС-ын үйлдвэрийн ажлын байранд өдөр, шөнийн ээлжид дуу чимээний хэмжилтийг хийж, өртөх эрсдэлийг үнэлсэн.

Хэмжилтийн үр дүнд MNS 6768:2019 стандартын ЗДХ (83дБА)-аас **1.1-2.6дБА-ээр өндөр буюу эрсдэлтэй хэмээн үнэлэгдсэн. Энэхүү үнэлгээ нь зөвхөн тухайн ажлын байранд ажиллах үеийн хэмжилт, үнэлгээ болно.**

**Захиргааны хяналт:** Дуу чимээний өртөх эрсдэлтэй ажилтнуудыг жил бүрийн ЭМУ-н хүрээнд чих хамар хоолойн үзлэгт хамруулсан

**НБХХ- хангах:** Сонгогч хамгаалах хэрэгслийг дотоод журмын дагуу олгох, ашиглуулж байна.

### IV.1.3 Тэсрэх материал, түүхий эдийн хадгалалт

Төслийн хэмжээнд нийт 6 агуулах ашиглалтад байгаа бөгөөд тус агуулахууд нь үндсэн түүхий эдийн, химийн бодисын, тэсэлгээний хэрэгслийн, болон бүтээгдэхүүн хадгалах зориулалттайгаар ашиглагдаж байна. Тус агуулахууд нь MNS 6458:2014 Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах, Ерөнхий шаардлага стандартыг бүрэн хангаж буйг Байгаль орчны улсын хяналтын байцаагчийн дүгнэлт хуудсаар баталгаажсан

#### Хяналт:

- Өдөр тутмын тойрох үзлэг- Үл тохирлыг газар дээр арилгуулах
- АБУ- Богино хугацааны үүрэг даалгавар – Салбарын хэмжээнд
- Төлөвлөгөөт хяналт шалгалт- Урт хугацааны үүрэг даалгавар –Компанийн хэмжээнд



#### ХИМИЙН БОДИС ХАДГАЛАХ ГТД АГУУЛАХ ШАЛГАХ ХУУДАС

Шалгалчийн нэр: ҮЧН Э.Нямжигмүүр Он сар: 2025.09.11  
Date: 2025.09.11

№	Шалгах асуумжууд	Тайлбар		Тайлбар
		Yes	No	
<b>Талбайн бодис, түүхий эд хадгалалт талбайн байгуулалт, барилгын бүрэн бүтэн байдал</b>				
1	Хэвийн бодис, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн хадгалалт агуулах, цементэн болон шороон хучилттай талбайд хадгалж гэмтэл, шүүр, гүдгэр байгаа эсэх?	✓		
2	Агуулахын дотор, доторх өмөг унах эрхлэл үүсээгүй эсэх?	✓		
3	Цемент хатуу хучилттай талбайн асгаралт цуглуулалт цугайн	✓		
4	Агуулах дотор талбайн гадаргуу хэвийн эсэх?	✓		
5	Агуулахын агааржуулалтын ажиглагч хэвийн эсэх?	✓		
6	Агуулахын орчны температур хэвийн эсэх? Хэдий гардуу байна вэ?	✓		
7	Агуулах дотор чана, тал хэвийн эсэх? Ямар юм мөхөж гэмтэл авалгүй эсэх?	✓		
<b>Төвлөмж хяналалт ажилтны ажиглагчийн хяналт</b>				
8	Хэвийн бодис, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүн хадгалалт талбай, агуулахад нэвтрэх эрхийг хянасан уу?	✓		
9	Хэвийн бодис, түүхий эдийн Хор Аюултай Лавил Материал (ХАЛМ) бүрэн, ашиглалтад ойлгомжтой байна уу?	✓		
10	Агуулахад ажиглагч ажилчин энэ ХАЛМ - и дотор ХХХ өмсөг, ноулууд ажиглагчийн хэргийг зөвхөн хэрэглэж байгаа эсэх?	✓		
11	Агуулахын талбайд өсөл, гэмтэлийн үед хэрэглэх агаарын тусламжийн хайрцаг, гал унтраалуур бүрэн ашиглалтад хэвийн байна уу?	✓		
12	Хэвийн бодис өрсөн төсөөлдөг ашиглах агаар угаагч, шуруур байна уу? Хэвийн ажиглагчтай байгаа эсэх?	✓		
<b>Талбайн бодисын асгаралт</b>				
13	Хэвийн бодис, түүхий эд, бүтээгдэхүүн хадгалалт агуулахад асгаралт ил тод харгалддаг байна уу?	✓		
14	Хэвийн бодис, түүхий эд, бүтээгдэхүүн хадгалалт талбайн ойр орчимд мөргөлдөө асгаралт үүссэн эсэх?	✓		
15	Хадгалалт талбайн асгаралтын үед хэрэглэх баглаж хэрэгсэл, шингээгч материал бүрэн байна уу? Дүрмээр гур, нүүр, мөсүүр, асгаралтын багц, өгзөг, махт сэг	✓		
16	Эгнэр шингээгч ил асгаралт хадгалалтын хэргийн бодист энэ тусламж байна уу? Мөн энэ хадгалалтад байгаа эсэх?	✓		
17	Хэвийн түүхий эд, бүтээгдэхүүн хадгалалт талбайд асгаралтын сурталын зориулалтын асгаралт цуглуулалт цугай байгаа эсэх?	✓		
<b>Талбайн бодис, түүхий эдийн хадгалалт, хяналалт, мөчлөгөөт</b>				
18	Хэвийн бодис, түүхий эдийн ХАЛМ-д хамсан шаардлагын дагуу бүрэн бүтэн сав баглаа бооцоо, зориулалтын талбайд ноулууд хадгалалтын уу?		✗	Натрийн нитратийг зурагдала гурав эхлээтэй зурагдала байсан. Операторын энэ хадгалалтыг эргэ болгон төлөвшүүлэх, энэ үйлд нөлөөлөхийн эргэ хэмжээг авч байх шаардлагатай.
19	Агуулахад хэвийн бодис, түүхий эдийн хяналалтын болон үл нөхцөлтэйгээр нь энэ ажиглагч хадгалалт байна уу?	✓		
20	Түүхий эд хадгалалт цементэн талбай, нэр, чанг, нислэгуулах тэмдэг тэмдэглэгээ бүрэн ойлгомжтой байна уу?	✓		
21	Хэвийн бодис, түүхий эдийн, сав баглаа бооцоо нэр, чанг, нислэгуулах тэмдэг тэмдэглэгээ бүрэн ойлгомжтой байна уу?	✓		
22	Агуулахад зуралттай түүхий эд нь зөвхөн тэвэрлэх шаардлага хадгалалт байна уу?	✓		
23	Энх явца (Агуулах болон талбайн дотор гал, өрч гурч ба зорчих хэргийг зуралдсан ил гүйц, мөргөлдөө байгаа эсэх)	✓		
24	Түүхий эдийн хадгалалт цуглаан өгсөөн дэх дарамал, шалгалт мөнгөжөөт хэрэгжүүлж байгаа эсэх?	✓		

#### Зөвлөмж-4.

- Түүхий эдийн хураах стандартыг тогтмол мөрдөх, түүнтэй холбоотой сургалт мэдээллийг өгөх.
- Ажилчдын сөрөг зан үйлийг эерэг зан үйл болгон төлөвшүүлэх ажил зохион байгуулах.
- Ээлжийн мастер болон удирдах ажилчид нь ажилчдад үзүүлэх талбай дээрх манлайлал, сургалт, заавар өгөх нь чухал байна.

#### Зураг 11. Химийн бодисын агуулах шалгах хуудас

## IV.1.4 Тээврийн хэрэгслийн үзлэг, засвар үйлчилгээ

МЖ7-03 Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварын норм журамд заасны дагуу доорх 4 төрлийн оношилгоо, үйлчилгээг хийж байна.

- Техникийн өдөр бүрийн үйлчилгээ
- Техникийг нэгдүгээр үйлчилгээ буюу оношилгоо, үйлчилгээ:
- Техникийн хоёрдугаар үйлчилгээ буюу гүнзгийрүүлсэн оношилгоо үйлчилгээ:
- Техникийн улирлын үйлчилгээ:

№	Салбар	Огноо	Улсын дугаар / марк	Улсын дугаар	Мот/цаг	Ажлын төрөл		Хийгдэх ажил
46	Налайх	5/6/2025	Сэрээт өргөгч /цахилгаан/ /1,5тн/ MFL-08	MFL-08	2279	Төлөвлөгөөт үзлэг	Урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт засвар	Төлөвлөгөөт үзлэг
47	Налайх	2025.05.06	Сэрээт өргөгч /1,5тн/ MFL-06	MFL-06	4082	Төлөвлөгөөт үзлэг	Урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт засвар	Төлөвлөгөөт үзлэг
48	Налайх	5/6/2025	22-52 УР Телехандлер /5тн/	22-52 УР	276	Төлөвлөгөөт бус засвар	Үндсэн системийн засвар	Хөргөлтийн систем
49	Налайх	5/6/2025	22-52 УР Телехандлер /5тн/	22-52 УР	276	Төлөвлөгөөт бус засвар	Үндсэн системийн засвар	Хөргөлтийн систем
50	Налайх	2025.05.06	MFL-03	MFL-03	3438	Төлөвлөгөөт үзлэг	Урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт засвар	Төлөвлөгөөт үзлэг
51	Налайх	5/7/2025	51-87УР Телехандлер /4тн/	51-87 УР	381,2	Төлөвлөгөөт үзлэг	Урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт засвар	Төлөвлөгөөт үзлэг
51	Налайх	5/7/2025	22-52 УР Телехандлер /5тн/	22-52 УР	276	Төлөвлөгөөт бус засвар	Үндсэн системийн засвар	Хөргөлтийн систем
380	Налайх	6/17/2025	САТ 422Е /Универсаль трактор/ /79-01 УБ	79-01 УБ	7267	Төлөвлөгөөт засвар	Үйлчилгээ, хэрэглээний засвар	Тосолгоо
	Налайх	6/17/2025	САТ 422Е /Универсаль трактор/ /79-01 УБ	79-01 УБ	7267	Төлөвлөгөөт засвар	Үйлчилгээ, хэрэглээний засвар	Тосолгоо
381	Налайх	6/16/2025	САТ 422Е /Универсаль трактор/ /79-01 УБ	79-01 УБ	7267	Төлөвлөгөөт засвар	Үндсэн системийн засвар	Хөргөлтийн систем
384	Налайх	6/13/2025	САТ 422Е /Универсаль трактор/ /79-01 УБ	79-01 УБ	7267	Төлөвлөгөөт засвар	Үндсэн системийн засвар	Хурдны хайршигын засвар
385	Налайх	6/12/2025	73-45 УНЗ Hyundai Mighty /3,5тн/	73-45 УНЗ	-	Урсгал засвар	Үндсэн системийн засвар	Цахилгааны засвар
386	Налайх	6/12/2025	САТ 422Е /Универсаль трактор/ /79-01 УБ	79-01 УБ	7267	Төлөвлөгөөт засвар	Үндсэн системийн засвар	Хөдөлгүүрийн засвар
615	Налайх	7/2/2025	САТ 422Е /Универсаль трактор/ /79-01 УБ	79-01 УБ	7274	Төлөвлөгөөт засвар	Үндсэн системийн засвар	Хөдөлгүүрийн засвар
834	Налайх	8/13/2025	51-87УР Телехандлер /4тн/	51-87 УР	383	Төлөвлөгөөт бус засвар	Үндсэн системийн засвар	Хурдны хайршигын засвар
835	Налайх	8/14/2025	51-87УР Телехандлер /4тн/	51-87 УР	383	Урсгал засвар	Үндсэн системийн засвар	Тосолгоо

Зураг 12. Тээврийн хэрэгслийн үзлэг, засварын бүртгэл

2025 онд салбарт нийт 2 удаагийн урсгал засвар, 10 удаагийн төлөвлөгөөт үзлэг засвар, 3 удаагийн төлөвлөгөөт бус засварыг хийж гүйцэтгэсэн байна.

ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ				
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Гүйцэтгэл
1	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн доройтол	Хөрсний мониторинг судалгааг жилд 1 удаа хийх, үр дүнг хянах	Үйлдвэрийн талбайд	ОХШХ-т дурьдав
2		Замын тоосжилтыг бууруулах зорилгоор зам засвар арчилгаа, усалгаа хийх	Төслийн хэмжээнд	Төсөл хэрэгжиж буй талбайн тээврийн хэрэгсэл болон явган зорчигчийн зорчих хэсэг нь хучилттай учир тоосжилт үүсэх нөхцөл бага байдаг. Үйлдвэр агуулахын бүс болон төв зам руу нийлэх уулзвар нь сайжруулсан замаар холбогдсон. Тайлант онд: Өвөлдөө цас цэвэрлэгээний ажил, зундаа орчны цэвэрлэгээ хийгдсэн байна.
3	Тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх. Тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS-ийн мэдээнд хяналт тавих	Төслийн хэмжээнд	Төслийн хүрээнд ашиглагдаж байгаа нийт тээврийн хэрэгсэл нь хурд хэмжигч суурилагдсан байдаг. Хурд хэмжигчийн хяналтыг МЭРА ХХК-ийн камер хяналтын нэгж 24 цагийн хугацаанд хянаж ажилладаг. Хэрэв хурд хэмжигчээр зөрчил илэрсэн тохиолдолд зөрчилд тооцон сануулж дотоод журмын дагуу арга хэмжээг авдаг
4		Хог хаягдлын менежмент төлөвлөгөө боловсруулж мөрдөж ажиллах	Төслийн хэмжээнд	Тайлант онд НС-н үйл ажиллагаанаас үүсэх дахивар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт гэрээний дагуу нийлүүлэх, Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээрх хадгалалтыг 90-ээс дээшгүй хоног хадгалан, эрх бүхий байгууллагад нийлүүлэх арга хэмжээг төлөвлөн ажилласан. Хог хаягдлын менежмент дээр дэлгэрэнгүй дурьдав.
5	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг ил задгай хаяснаар хөрс бохирдох Химийн бодис тээвэрлэх, хадгалах,	Хог хаягдлын сав, цэгийн тохижилт, засвар үйлчилгээг тогтмол хийх	“Мера ХХК”	ХАБЭАБО-ны хэлтсийн АБҮ-н хуваарийн дагуу төсөл хэрэгжих талбайд хог хаягдлын ангилан ялгалт, асгаралт, түр хадгалах цэгийн эмх цэгцтэй байдал, хог хаягдлын хуримтлал, хогийн савны бүрэн бүтэн байдал зэрэгт үзлэг хийж үл тохирол арилгах тухай тайланг хэлтэс нэгжийн ахлахуудад илгээж үл тохирлыг арилгах хугацаат үүрэг даалгавар өгч ажилладаг.

6	ашиглахтай холбогдон гарах нөлөөлөл	Бүх төрлийн химийн бодис, шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, системээс хол, нарны гэрэл шууд тусахааргүй, үер усанд автахааргүй нөхцөлд хадгалах	Төслийн хэмжээнд	
7		Тэсэлгээний бодис, материал хүлээн авах талбай, агуулах, үйлдвэрийн барилга байгууламж, шал зэрэгт байнгын үзлэг шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд дор нь засварлах.	Төслийн хүрээнд	

### IV.2.1 Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын түр хадгалах цэгийн үзлэг, засвар, сайжруулалт

ХАБЭАБО-ны хэлтсийн АБҮ-н хуваарийн дагуу төсөл хэрэгжих талбайд хог хаягдлын ангилан ялгалт, асгаралт, түр хадгалах цэгийн эмх цэгцтэй байдал, хог хаягдлын хуримтлал, хогийн савны бүрэн бүтэн байдал зэрэгт үзлэг хийж үл тохирол арилгах тухай тайланг хэлтэс нэгжийн ахлахуудад илгээж үл тохирлыг арилгах хугацаат үүрэг даалгавар өгч ажилладаг.

2025 оны мөн үеийн байдлаар нийт 34 удаагийн ажлын байрны үзлэг хийгдсэн ба үүний 5-д нь асгаралт, хог хаягдлын ангилан ялгалт, ажлын байрны эмх цэгцтэй холбоотой үл тохирол бүртгэгдэж тайлангаар мэдээлэгдэж, үл тохирлыг арилгах арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлсэн байна.

ны үзлэгийн бүртгэл						
№	Огноо	Компани	Салбар	Илэрсэн ноцтой зөрчил	Аюулын зэрэг	Илэрсэн үл тохирлын тоо
6	1/16/2025	МЕРА	Налайх	Ажлын байрны эмх цэгц алдагдсан	бага	9
19	2/13/2025	МЕРА	Налайх	Ажлын байрны эмх цэгцгүй ажилласан	бага	7
25	2/27/2025	МЕРА	Налайх	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийн хэрэглээ, ажлын байрны эмх цэгц	дунд	6
32	3/13/2025	МЕРА	Налайх			4
33	3/13/2025	МЕРА	Налайх	Цахилгааны самбар, ханын розетка, тэмдэг тэмдэглэгээ.	дунд	4
40	3/27/2025	МЕРА	Налайх	Цахилгааны самбар, ханын розетка, тэмдэг тэмдэглэгээ.	дунд	5
44	4/10/2025	МЕРА	Налайх	Ил шалбархай цахилгааны утас	дунд	4
49	4/17/2025	МЕРА	Налайх	Үйлдвэр агуулахын бүсийн тэмдэг тэмдэглэгээ, бүрэн бүтэн байдал, эмх цэгц, асгаралт, цахилгааны холболт, унтраалга шаардлага хангахгүй	дунд	40
54	5/1/2025	МЕРА	Налайх	Эвдрэл гэмтэл	бага	5
56	5/8/2025	МЕРА	Налайх	Хаалга, тэмдэг тэмдэглэгээ, цахилгааны утас	бага	5
63	5/20/2025	МЕРА	Налайх	T11 оёх дамжлага fishben загварын оёдлын машин ажиллах явцад оёдлын утсаа зуугаад ойр ойрхон тасардаг.	дунд	5
64	5/22/2025	МЕРА	Налайх	Гэр багаж, цахилгаан багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж.	бага	4
71	6/5/2025	МЕРА	Налайх	Ажлын байрны эмх цэгц, эрүүл ахуй.	бага	5
76	6/19/2025	МЕРА	Налайх	Асгаралт, болон АХХ хадгалалт	дунд	5
81	7/3/2025	МЕРА	Налайх	Эрүүл ахуйтай холбоотой үл тохирол буюу тааз хөгцөрч мөөгөнцөртсөн, агуулахын хашлага бүрэн бус, T11 агуулахын хана цууралттай.	дунд	10
84	7/17/2025	МЕРА	Налайх	Хог хаягдал, сарайн зарим багаж эвдэрсэн, хаалганы баруу эвдэрсэн, асгаралт.	дунд	7
89	7/31/2025	МЕРА	Налайх	Асгаралт, ажлын байрны эмх цэгц, хаалга үүд, цахилгааны ажил	дунд	7
90	8/14/2025	МЕРА	Налайх	Асгаралт, хог хаягдал, ажлын байрны эмх цэгц, тоног төхөөрөмж.	дунд	8
97	9/9/2025	МЕРА	Налайх	Лаборатор АА хангагдаагүй Тэмдэг тэмдэглэгээ дугаар T14 галын дохиолол, систем	Их	10

Зураг 13. Ажлын байрны үзлэгийн бүртгэл

#### IV.2.2 Химийн бодис шатамхай шингэний хадгалалт

Химийн бодис, шатамхай шингэний хадгалалтыг стандарт шаардлага хангасан агуулахад хадгалж байна.



Зураг 14. Түүхий эд, шатах материалын хадгалалт

#### IV.2.3 Химийн бодис, түүхий эд, хүлээн авах зам талбай, агуулахын шал зэрэгт үзлэг хийж бүрэн бүтэн байдлыг хангах

Үйлдвэр агуулахын бүсийн нийт барилга байгууламж, объектуудад нэгдсэн үзлэгийг тухайн жилийн 6-р сард хийж гүйцэтгэсэн. Тус үзлэгийн хүрээнд дотоод журмын хавсралт хяналтын хуудсыг ашиглан үзлэгийг хийж, зургаар баримтжуулан тайланг гүйцэтгэсэн.

Үзлэгээр үйлдвэр, авто засварын газар, химийн лаборатори, оффис, түүхий эдийн агуулах, химийн бодисын агуулах зэрэг объектуудад үзлэг хийж нийт 27 үл нийцлийг илрүүлж тайланг бэлтгэж мэдээллийг илгээсэн.

Үйлдвэр, агуулах, түүхий эдийг зөөвөрлөх талбайд үл тохирол илрээгүй.

## Налайх салбарын барилга байгууламжид хийгдсэн үзлэгийн үл тохирлын тайлан

2025 он

### ХАБЭАБО-НЫ ХЭЛТЭС

Зураг 15. Барилга байгууламжийн үзлэг шалгалтын тайлан

#### 3.Т13 үйлдвэр үзлэг шалгалтаар илэрсэн үл тохирлууд

1.Обектын цахилгааны самбараас зорцуулалтын бусаар

Цахилгаан тэжээлийн утас салаалж авсан

2.Үйлдвэрлэл явагдаж байгаа обектын шалыг

резинен будгаар будаагүй



Зураг 16. Үзлэгээр илэрсэн үл тохирол

ХАБЭА Мянгат №.....

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖ ШАЛГАХ ХУУДАС**

Үзлэг хийсэн баг: <i>ХАБЭА БО-ны мэргэжилтэн З.Дам-Орш</i>
Үзлэг хийсэн ажлын байр, талбар: Т15 үйлдвэр
Талбай харнуусан ажилтан: <i>Ерөнхий инженер М. Дугарбаатар</i>

2025 оны 10 сарын 29

Шалгах үзүүлэлтүүд		Шалгуур оноо		Илэрсэн зөрчил
1	Дотор гэрэлтүүлэг	3	3	<i>Шор бүсийн тэрэг дэвдэр бийрлэсэн.</i>
2	Гадна гэрэлтүүлэг	3	3	
3	Гал унтраагуух хэрэгсэл, галын дохиолол	3	3	
4	Хаалганууд	25	3	<i>2 хаалганы болууд өвдөрлөн.</i>
5	Цонх, сараалжийн бүтэн байдал	3	3	
6	Байгууламжийн эмх цэгц	3	3	
7	Ажлын байран дахь эмийн сан	3	3	
8	Цахилгааны аюулгүй байдал	3	3	
9	Бараа материалын хадгалалт	3	3	
10	Эрүүл ахуй, цэвэрлэгээ, өнгө үзэмж	2	3	<i>Галын шонд будал лавлагаа үрчин дордуулсан.</i>
		<b>385</b>	<b>30</b>	

Авах ёстой онооноос авсан оноог хувьчилж дүнг гаргана.  
 90%-100% - Ажлын байр аюул эрсдэл бага ба ажлыг үргэлжлүүлж байна.  
 80%-90% - Ажлын байрны эрсдэл дунд ба ажлын удирдагч, мастер, механикт анхааруулна. Ажлын байрны үзлэгийн тайланг гаргаж салбар нэгж харуулсан ахлах ажилтан, инженер, механикт өгнө.  
 80%-с бага нөхцөлд ажлыг зогсоож, салбар нэгж харуулсан ахлах ажилтанд даруй мэдэгдэж, аюул эрсдэлийг арилгах ажлыг зохион байгуул. Ажлын байрны үзлэгийн тайланд заагдсан хугацаанд дахин ажлын байрны үзлэг хийж, аюул эрсдэл арилсан эсхийг нарийвчлан шалгана. Тайланг Гүйцэтгэх захиралд хургуулна.

Зураг 17. Үзлэгийн хуудас

УСАН ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ					
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Бараа материалын тээвэр хийх хүнд машин механизмын хөдөлгөөнөөр үүссэн бохирдол болон хог хаягдал нь үерийн усаар зөөгдөх	Ахуйн хуурай хог хаягдлын цэг болон шингэн хаягдлыг зайлуулах цэг, машин техникийн зогсоол зэргийг жалга, суваг шуудуунаас хол зайд байрлуулах	Төслийн талбайд	Тогтмол	Ахуйн хог хаягдлыг үйлдвэр агуулахын бүсэд битүү саванд түр хадгалаад шилжүүлдэг ба үйлдвэр агуулахын бүсийг тойрсон <b>үерийн суваг шуудуунаас хамгийн багадаа 10 метрийн зайд байрлаж байна.</b> Тээврийн хэрэгслийн зогсоол нь суваг шуудуунаас мөн <b>10 метрийн зайд байрлах бөгөөд далангаар өндөрлөсөн байдаг</b> тул үерийн ус өнгөрөх сувагт сөргөөр нөлөөлөх эрсдэл багатай юм.
2	Тэсэлгээний хорт болон аюултай бодисыг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс бодис алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Төслийн үйлдвэр болон агуулах орчмын үерийн хамгаалалт, даланд хур борооны улиралд үзлэг шалгалт хийж, засварлаж байх	Төслийн хэмжээнд	2025 онд	2025 онд тохиосон хур борооны улмаас <b>үйлдвэр агуулахын бүс, барилга байгууламж усны нэвтрэлт, нуралт үүсээгүй.</b> Үйлдвэр, агуулахын бүсийг бүтэн тойрсон үерийн шуудууны бүрэн бүтэн байдал, хог хаягдлын бохирдолд салбарын ХАБЭАБОМ болон мастерууд тогтмол хяналт тавьж тойрох үзлэг хийж ажилладаг.
3	Үйлдвэр ахуйн ус алдагдаж, гадаргын болон газрын доорх усны нөөцийг бохирдуулах	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжид тушаах	Үйлдвэрийн оффис	2025 онд	Эрх бүхий байгууллагаар гэрээний дагуу нийлүүлэлтийг хийж байна.

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ					
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Гүйцэтгэл
1	Хүний эрүүл мэнд	Ажилтнуудыг тусгай хувцас хэрэгслээр бүрэн хангах	Химийн бодистой харьцаж ажилладаг бүх ажилчид	Үйл ажиллагааны туршид	Тухайн жилийн ХАБЭАБОХ-н төсөв болон байгууллагын хувцас хамгаалах хэрэгслээр хангах дотоод журмын дагуу хэрэгжүүлж байна.
2		Ажилтнуудыг эмнэлгийн нарийн мэргэжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах		Жилд нэг удаа	Ажлын байрны нөхцөлд тохирсон эрүүлд мэндийн багц үзлэгийн Дөрөвдүгээр эмнэлэгтэй гэрээ байгуулан хийлгэсэн. Дэлгэрэнгүйтэй V.2-оос танилцана уу.
3		Нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах		Үйл ажиллагааны туршид	Байгууллагын хувцас, хамгаалах хэрэгсэл олгох журмын хүрээнд НБХХ-ын олголтыг нормын дагуу тухай бүр олгож байна. Дэлгэрэнгүйтэй V.3-аас танилцана уу.
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, гал түймэр, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах		2025 онд	Төслийн хэмжээнд ажиллаж байгаа нийт ажилтанд байгууллагын сургалтын журмын дагуу хэд хэдэн үе шат бүхий сургалтыг олгодог. Салбарын ажилтнуудад нийт 1463 хүн/цаг-н дотоод болон гадаад сургалтыг олгосон байна. Дэлгэрэнгүйтэй V.4 -өөс танилцана уу.
5	Төслөөс байгаль орчин, нийгэм эдийн засагт	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулж үйл ажиллагаандаа мөрдөх	Үйл ажиллагааны дотоод төлөвлөлтөөр	2 жилд 1 удаа	Тухайн жилийн галын аюулгүй байдлын дүгнэлт хуудсыг шинэчлэн гаргуулсан. Дэлгэрэнгүйтэй V.5-аас танилцана уу
